

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
ДААТГАЛЫН ГАЗАР

ДААТГАЛЫН САЛБАРЫН 2012 ОНЫ 3 ДУГААР  
УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

**ТАНИЛЦСАН:**

ХОРООНЫ ДАРГА	Д. БАЯРСАЙХАН
ХОРООНЫ ГИШҮҮН	Г. ХЭРЛЭН
ХОРООНЫ ГИШҮҮН	Б. ДААЖАМБА
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА	Х. БУМ-ЭРДЭНЭ

**ХЯНАСАН:**

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА	С. ГАНБОЛД
ДААТГАЛЫН ГАЗРЫН БТХ-ИЙН ДАРГА	П. ЦЭРЭНДЭЖИД

**БОЛОВСРУУЛСАН:**

ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАН ШАЛГАГЧ	Э. ЭРДЭНЭТУЯА
--------------------------------	---------------

УЛААНБААТАР ХОТ

2012.11.08

## ГАРЧИГ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

- 1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
- 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ
- 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 1.6 ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА
- 1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 1.9 ДАВХАР ДААТГАЛ

### ХОЁРДУГААР БҮЛЭГ.ЕРДИЙН ДААТГАЛ

- 2.1 ЕРДИЙН ДААТГАЛ
- 2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ
- 2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА
- 2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ
- 2.10 МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСАН ДААТГАЛЫН ТАЛААР

### ГУРАВДУГААР БҮЛЭГ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

- 3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ
- 3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР
- 3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГ, НӨӨЦ САН

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

- 4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ
- 4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

### ДҮГНЭЛТ

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2012 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН  
САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА  
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ**

**1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

2012 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 18 компани, 219 даатгалын салбар, 2436 даатгалын төлөөлөгч, 13 даатгалын зуучлагч компани, 9 даатгалын хохирол үнэлэгч компани, 15 актуарч, нийт 2491 тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулж байна.

(Хүснэгт-1)

**Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо**

№	Он	2009-III	2010-III	2011-III	2012-III
1	Даатгагч	17	16	17	18
1.1	Даатгалын компанийн салбар	130	136	152	219
3	Даатгалын төлөөлөгч	1639	1998	2080	2436
4	Даатгалын зуучлагч	4	8	8	13
5	Даатгалын хохирол үнэлэгч		6	8	9
6	Даатгалын актуарч		10	12	15
	<b>Бүгд</b>	1660	2038	2125	2491

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо нь энэ оны 3 дугаар улирлын байдлаар 2011 оны мөн үеэс 1.17 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүнд мэргэжлийн оролцогчдын тооны өсөлт нөлөөлсөн байна.

(График-1)




## 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

2012 оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 18 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 100.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.9 тэрбум төгрөг буюу 1.3 дахин өссөн байна. Мөн 2009 оны мөн үетэй харьцуулахад 61.6 тэрбум төгрөг буюу 2.6 дахин өссөн дүнтэй байна.

(График-2)

### Даатгагчийн нийт хөрөнгийн хэмжээ / тэрбум төгрөгөөр/



Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2011 оны 3 дугаар улиралд 61.3 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 79.3 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 16.0 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 20.7 хувийг эзэлж байсан бол 2012 оны мөн үед эргэлтийн хөрөнгө 83.5 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 83.0 хувь, эргэлтийн бус хөрөнгө 17.3 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 17.0 хувийг эзэлж байна.

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеийнхээс 20.1 тэрбум төгрөг буюу 1.4 дахин өссөн нь дүрмийн сангийн доод хэмжээг нэмсэнтэй холбоотой юм. Харин нийт хөрөнгөд эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувийн жин өмнөх оны мөн үеэс буурч, эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувийн жин өссөн. Энэ нь дүрмийн сангийн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой.

(Хүснэгт-2)

### Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2011-III		2012-III		Өсөлт/ бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	61,360.0	79.3	83,536.9	83.0	22,176.9	3.7
Эргэлтийн бус хөрөнгө	16,038.4	20.7	17,264.2	17.0	1,225.8	-3.7
Нийт хөрөнгө	77,398.5	100.0	100,801.1	100.0	23,402.6	-

2012 оны 3 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 56.28 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 27.93 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 13.17 хувийг дансны авлага, үлдэх 2.61 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад богино хугацаат хөрөнгө оруулалт 1.74 пунктээр, дансны авлага 3.35 пунктээр, бусад эргэлтийн хөрөнгө 1.59 пунктээр тус тус өсч, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 6.69 пунктээр буурсан байна.

Нийт авлагын 50 хувийг 4 компанийн авлага эзэлж байна.

(Хүснэгт-3)

### Эргэлтийн хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2011-03 улирал		2012-03 улирал		Өөрчлөлт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	38,637.10	62.97	47,014.80	56.28	8,377.70	(6.69)
<b>Богино хугацаат хөрөнгө оруулалт</b>	16,070.70	26.19	23,335.90	27.93	7,265.20	1.74
<b>Дансны авлага</b>	6,026.10	9.82	11,002.80	13.17	4,976.70	3.35
<b>Бусад эргэлтийн хөрөнгө</b>	626.10	1.02	2,183.40	2.61	1,557.30	1.59
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>61,360.00</b>	<b>100.00</b>	<b>83,536.90</b>	<b>100.00</b>	<b>22,176.90</b>	<b>(0.00)</b>

2012 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 21.3 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 21.2 хувийг, “Жонон даатгал” ХХК хамгийн бага буюу 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 1.6 хувийг эзэлж байгаа бол эхний 3 компани нийт хөрөнгийн 38.5 хувийг эзэлж, даатгалын салбар дахь хөрөнгийн төвлөрлийн хэмжээ буурсан байна.

(Хүснэгт-4)


/сая төгрөгөөр/

№	Даатгагчийн нэр	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	“Ард даатгал” ХХК	6,134.5	6.1
2	“Бодь даатгал” ХХК	10,005.1	9.9
3	“Ган зам даатгал” ХХК	2,560.4	2.5
4	“Мандал женерал даатгал” ХХК	6,591.5	6.5
5	“Жонон даатгал” ХХК	1,603.5	1.6
6	“МИГ даатгал” ХХК	6,865.4	6.8
7	“Монгол даатгал” ХХК	21,374.5	21.2
8	“Гэр даатгал” ХХК	1,931.3	1.9
9	“Моннис даатгал” ХХК	2,729.2	2.7
10	“Мөнх даатгал” ХХК	2,980.8	3.0
11	“Номин даатгал” ХХК	5,954.9	5.9
12	“Нэйшнл лайф даатгал” ХХК	3,455.8	3.4

13	“Практикал даатгал” ХХК	7,474.9	7.4
14	“Тэнгэр даатгал” ХХК	6,668.7	6.6
15	“Соёмбо даатгал” ХХК	6,729.4	6.7
16	“Монре даатгал” ХХК	3,125.0	3.1
17	“УБ хотын даатгал” ХХК	2,623.7	2.6
18	“Хаан даатгал” ХХК	1,989.7	2.0
	ДҮН	100,798.3	100.0

### 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 3 жилийн 3 дугаар улирлын байдлаар харьцуулж харахад дараах байдалтай байна. /График-3/



Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2010 оны 3 дугаар улиралд 58.3 хувийг эзэлж байсан бол 2011 оны 3 дугаар улиралд 44.9 хувь, 2012 оны 3 дугаар улиралд 47.0 хувь эзлэх болж өссөн нь орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн өсөлттэй холбоотой байна.

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2009 оноос хойш тогтвортой өсч ирсэн бөгөөд тайлант үед 81.72 хувийг эзэлж байна. Харин өр төлбөрийн эзэмшигчдийн өмчид эзлэх харьцаа өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр буурсан байна. (Хүснэгт-5)

#### Эзэмшигчдийн өмч

Үзүүлэлтүүд	2011 - III		2012 - III		Өсөлт бууралт	
	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь
Эзэмшигчдийн өмч	30,154.5	78.65	40,370.8	81.72	10,216.3	3.07
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	8,186.3	21.35	9,028.6	18.28	842.3	(3.07)

/сая төгрөгөөр/

Эзэмшигчдийн өмчийн дүн	38,340.8	100.00	49,399.4	100	11,058.6
-------------------------	----------	--------	----------	-----	----------

Тайлант үеийн эзэмшигчдийн өмчийн дүн 2011 оны мөн үеийнхтэй харьцуулахад 11.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хуримтлагдсан ашиг сүүлийн 2 жилд тогтвортой нэмэгдэж ирсэн бөгөөд энэ нь даатгалын компаниудын цэвэр ашгийн өсөлттэй уялдаатай байна.

#### 1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2012 оны 3 дугаар улиралд 59,918.3 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7 дахин өссөн байна. Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагчид нийт 59,488.1 сая төгрөг, урт хугацааны даатгагч 430.2 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Ердийн даатгалын орлого өмнөх оны мөн үеийнхээс 23,661.4 сая төгрөгөөр, урт хугацааны даатгалын орлого 202.3 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээ нь 16,832.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Даатгалын хэлбэрээр 2012 оны 3 дугаар улирлын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад хөрөнгийн даатгал 5,233.1 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн даатгал 2,382.4 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 1,724.8 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 702.8 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 534.9 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 11,007.5 сая төгрөгөөр, ачааны даатгал 310.7 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 31.6 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 31.8 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 105.3 сая төгрөгөөр, барилга угсралтын даатгал 1,653.4 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 148.4 сая төгрөгөөр, мал амьтдын даатгал 6.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, зөвхөн тэтгэврийн даатгал 9.4 сая төгрөгөөр буурсан байна.

(Хүснэгт-6)  
/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)		Өөрчлөлт /+/, /-/
	2011.09.30	2012.09.30	
1.2. Хөрөнгийн даатгал	9,316.5	14,549.6	5,233.1
1.3. Авто тээвэр хэрэгслийн даатгал	9,187.5	11,569.9	2,382.4
1.8. Агаарын хөлгийн даатгал	4,078.9	5,803.7	1,724.8
1.10. Хариуцлагын даатгал	4,613.3	5,316.1	702.8
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	4,120.1	4,655.0	534.9
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	2,341.4	13,348.9	11,007.5
1.11. Санхүүгийн даатгал	1,201.1	1,306.4	105.3
1.5. Барилга угсралтын даатгал	175.7	1,829.1	1,653.4
1.4. Ачааны даатгал	790.6	1,101.3	310.7
2.1. Хугацаат амьдралын даатгал	62.8	211.2	148.4
2.5. Эрүүл мэндийн даатгал	70.4	102	31.6
1.7. Мал амьтдын даатгал	1.4	8	6.6
1.6. Газар тариалангийн даатгал			0.0
2.3. Хуримтлалын даатгал	58.8	90.6	31.8
2.4 Тэтгэврийн даатгал	35.9	26.5	-9.4

<b>ДҮН</b>	<b>36, 054.4</b>	<b>59, 918.3</b>	<b>23,863.9</b>
------------	------------------	------------------	-----------------

### 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2012 оны 3 дугаар улиралд нийт 12999.0 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосноос 2764.3 сая төгрөгийг давхар даатгалаас, 10,234.7 сая төгрөгийг шууд даатгалаас тус тус олгосон байна. Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс мал амьтдын даатгал 5.8 сая төгрөгөөр буурч, хөрөнгийн даатгал 92.1 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн даатгал 1,067.2 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 3.1 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 115.4 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 398.4 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 1,557.2 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 227.6 сая төгрөгөөр, ачааны даатгал 90.3 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 22.7 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 26.1 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 41.3 сая төгрөгөөр, тэтгэврийн даатгал 4.0 сая төгрөгөөр, барилга угсралтын даатгал 11.2 сая төгрөгөөр тус тус өсч, мал амьтдын даатгал 5.8 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэйгээр нөхөн төлбөрт олгогджээ.

(Хүснэгт-7)

/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	2011.09.30	2012.09.30	Өөрчлөлт
	Даатгалын нийт нөхөн төлбөр(сая.төг)		
1.2. Хөрөнгийн даатгал	1,000.0	1,092.1	92.1
1.3. Автотээврийн хэрэгслийн даатгал	3,170.9	4,238.1	1,067.2
1.8. Агаарын хөлгийн даатгал	5.6	8.7	3.1
1.10. Хариуцлагын даатгал	290.7	406.1	115.4
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	803.3	1,201.7	398.4
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	673.9	2,231.1	1,557.2
1.11. Санхүүгийн даатгал	528.8	756.4	227.6
1.5. Барилга угсралтын даатгал		11.2	11.2
1.4. Ачааны даатгал	63.1	153.4	90.3
2.1. Хугацаат амьдралын даатгал	16.3	39	22.7
2.5. Эрүүл мэндийн даатгал	13.5	39.6	26.1
1.7. Мал амьтдын даатгал	5.8		-5.8
1.6. Газар тариалангийн даатгал	-	-	-
2.3. Хуримтлалын даатгал	11.8	53.1	41.3
2.4 Тэтгэврийн даатгал		4	4
<b>ДҮН</b>	<b>6,583.7</b>	<b>10,234.5</b>	<b>3,650.8</b>

### 1.6 ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН



2012 оны 3 дугаар улиралд даатгалын нөхөн олговрын түвшин даатгалын салбарын дүнгээр 29.7 хувь болж 2011 оны мөн үеийнхээс 0.7 пунктээр буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж түвшин 31.2 хувьтай байна.

(График-4)



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын нөхөн олговрын түвшингээр харьцуулахад 2012 оны 3 дугаар улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК 36.6 хувь, “Соёмбо даатгал” ХХК 35.5 хувь, “Ард даатгал” ХХК 34.2 хувьтай буюу хамгийн өндөр хувьтай байна.

(Хүснэгт-8)

№	Даатгагчийн нэр	Нөхөн олговрын түвшин		Өсөлт бууралт /пунктээр/
		2011-03	2012-03	
1	“Ард даатгал” ХХК	31.2	34.2	3.08
2	“Бодь даатгал” ХХК	26.3	28.2	1.92
3	“Ган зам даатгал” ХХК	7.8	4.5	-3.28
4	“Мандал женерал даатгал” ХХК	0.0	0.0	0.00
5	“Жонон даатгал” ХХК	99.4	0.0	-99.41
6	“МИГ даатгал” ХХК	27.0	33.6	6.62
7	“Монгол даатгал” ХХК	35.1	36.6	1.52
8	“Гэр даатгал” ХХК	24.3	22.0	-2.33
9	“Моннис даатгал” ХХК	10.3	14.4	4.04
10	“Мөнх даатгал” ХХК	19.0	14.0	-5.04
11	“Номин даатгал” ХХК	40.9	30.4	-10.50
12	“Нэйшнл лайф даатгал” ХХК	24.3	31.6	7.29
13	“Практикал даатгал” ХХК	16.3	21.0	4.70
14	“Тэнгэр даатгал” ХХК	30.3	25.7	-4.56
15	“Соёмбо даатгал” ХХК	36.3	35.5	-0.83
16	“Монре даатгал” ХХК	32.8	18.6	-14.29
17	“УБ хотын даатгал” ХХК	20.6	12.6	-8.00
18	“Хаан даатгал” ХХК	0	0	0.00
	ДҮН	30.4	29.7	-0.70

Даатгалын компаниудаас 2010 оны 3 дугаар улиралд даатгуулагчдад олгосон даатгалын хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ард даатгал” ХХК 3.08 пунктээр, “Бодь даатгал” ХХК 1.92 пунктээр, “Миг даатгал” ХХК 6.62 пунктээр, “Монгол даатгал” ХХК 1.52 пунктээр, “Моннис даатгал” ХХК 4.04 пунктээр, “Нэйшнл лайф даатгал” ХХК 7.29 пунктээр, “Практикал даатгал” ХХК 4.7 пунктээр тус тус нэмэгдэж “Гэр даатгал” ХХК 2.33 пунктээр “Номин даатгал” ХХК 10.5 пунктээр, “Монре даатгал” ХХК 14.29 пунктээр “Соёмбо даатгал” ХХК 0.83 пунктээр, “Мөнх даатгал” ХХК 5.04 пунктээр, “Ган зам даатгал” ХХК 3.28 пунктээр, “Тэнгэр даатгал” ХХК 4.56 пунктээр, “Улаанбаатар хотын даатгал” ХХК 8.0 пунктээр тус тус буурсан байна.

### 1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА


2012 оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 5288.8 сая төгрөг байна.

(Хүснэгт-9)

№	Даатгагчийн нэр	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь
1	“Ард даатгал” ХХК	299.7	5.7
2	“Бодь даатгал” ХХК	370.7	7.0
3	“Ган зам даатгал” ХХК	339.4	6.4
4	“Мандал женерал даатгал” ХХК	(61.5)	-
5	“Жонон даатгал” ХХК	94.9	1.8
6	“МИГ даатгал” ХХК	524.2	9.9
7	“Монгол даатгал” ХХК	1,216.5	23.0
8	“Гэр даатгал” ХХК	12.5	0.2
9	“Моннис даатгал” ХХК	509.4	9.6
10	“Мөнх даатгал” ХХК	60.9	1.2
11	“Номин даатгал” ХХК	464.6	8.8
12	“Нэйшнл лайф даатгал” ХХК	(142.2)	-
13	“Практикал даатгал” ХХК	585.3	11.1
14	“Тэнгэр даатгал” ХХК	612.5	11.6
15	“Соёмбо даатгал” ХХК	132.5	2.5
16	“Монре даатгал” ХХК	177.8	3.4
17	“УБ хотын даатгал” ХХК	118.7	2.2
18	“Хаан даатгал” ХХК	(27.1)	-
	<b>Дүн</b>	<b>5,288.8</b>	<b>100.0</b>

2012 оны 3 дугаар улиралд “Нэйшнл лайф даатгал” ХХК 142.2 сая төгрөг, “Мандал женерал даатгал” ХХК 61.5 сая төгрөг, “Хаан даатгал” ХХК 27.1 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан ба энэ нь нийт даатгалын салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлсөн байна.

(График-5)




Хуримтлагдсан ашгийн хэмжээ 2010 оноос тогтвортой өсч ирсэн бөгөөд 2012 оны 03 дугаар улирлын байдлаар тайлант үеийн ашиг 5288.8 сая төгрөг, хуримтлагдсан ашгийн хэмжээ 9028.6 сая төгрөг болж өссөн байна.

### 1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 3 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн байна. 2010 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын нөөц 26.7 тэрбум байсан бол 2011 оны мөн үед 34.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 8.0 тэрбумар нэмэгдсэн байна. 2012 оны мөн үед даатгалын нөөц сангийн үлдэгдэл 2011 оны мөн үеийнхээс 12.2 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

(График-6)



### 1.9 ДАВХАР ДААТГАЛ

2012 оны 3 дугаар улиралд даатгалын компаниуд гадаадын давхар даатгалын компаниудад их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж 16.3 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 7.6 тэрбум төгрөгөөр буюу 1.9 дахин өссөн дүнтэй гарсан байна.

(График-7)



(Хүснэгт-10)

(сая төгрөгөөр)

№	Даатгагчийн нэр	2011-III		2012-III		Өөрчлөлт	
		ТОО	ХУВЬ	ТОО	ХУВЬ	ТОО	ХУВЬ
1	“Ард даатгал” ХХК	1357.3	15.55	2,683	16.42	1,325.7	0.87
2	“Бодь даатгал” ХХК	2,933.5	33.60	4,305.6	26.34	1,372.1	(7.26)
3	“Тэнгэр даатгал” ХХК	279.2	3.20	571.6	3.50	292.4	0.30
4	“Практикал даатгал” ХХК	188.5	2.16	145.4	0.89	-43.1	(1.27)
5	“Миг даатгал” ХХК	938.9	10.76	1,487.9	9.10	549.0	(1.65)
6	“Монгол даатгал” ХХК	517.5	5.93	3,740.8	22.89	3,223.3	16.96
7	“Номин даатгал” ХХК	95.2	1.09	25.6	0.16	-69.6	(0.93)
8	“Нэйшнл лайф даатгал” ХХК	56.5	0.65	11.2	0.07	-45.3	(0.58)
9	“Монре даатгал” ХХК	23.4	0.27	65.7	0.40	42.3	0.13
10	“Соёмбо даатгал” ХХК	1,557.6	17.84	1,196.5	7.32	-361.1	(10.52)
11	“УБ хотын даатгал” ХХК	27.0	0.31	-	-	-27.0	(0.31)
12	“Ган зам даатгал”	101.7	1.17	170.5	1.04	68.8	(0.12)
13	“Моннис даатгал” ХХК	653.1	7.48	1,077.7	6.59	424.6	(0.89)
14	“Мандал женерал даатгал” ХХК	-	-	861.9	5.27	861.9	5.27
	<b>Дүн</b>	<b>8,729.4</b>	<b>100.0</b>	<b>16,343.4</b>	<b>100.0</b>	<b>7,614</b>	

2012 оны 3 дугаар улиралд гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2011 оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ард даатгал” ХХК 1325.7 сая төгрөгөөр, “Бодь даатгал” ХХК 1372.1 сая төгрөгөөр, “Тэнгэр даатгал” ХХК 292.4 сая төгрөгөөр, “Миг даатгал” ХХК 549.0 сая төгрөгөөр, “Монгол даатгал” ХХК 3223.3 сая төгрөг, “Монре даатгал” ХХК 42.3 сая төгрөг, “Ган зам даатгал” ХХК 68.8 сая төгрөгөөр, “Моннис даатгал” ХХК 424.6 сая төгрөгөөр, “Мандал женерал даатгал” ХХК 861.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, “Практикал даатгал” ХХК 43.1 сая төгрөгөөр, “Нэйшнл лайф даатгал” ХХК нь 45.3 сая төгрөгөөр, “Соёмбо даатгал” ХХК 361.1 сая төгрөгөөр, “УБ хотын даатгал” ХХК 27.0 сая төгрөгөөр, “Номин даатгал” ХХК 69.6 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ.ЕРДИЙН ДААТГАЛ

## 2.1 ЕРДИЙН ДААТГАЛ


2012 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 17 ердийн даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Ердийн даатгалын компанийн салбар 219 болсон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 67-оор нэмэгдсэн байна.

## 2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 17 даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 97.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 23.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. (График-8)

### Ердийн даатгагчийн нийт хөрөнгийн хэмжээ

/тэрбум төгрөгөөр/



## 2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Эзэмшигчийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2011 оноос тогтвортой өссөн байна.

(Хүснэгт-11)

/сая төгрөгөөр/

Санхүүгийн үзүүлэлт	2011 - III		2012 - III		Өсөлт бууралт	
	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь
Эзэмшигчдийн өмч	19717.9	68.77	36677.2	78.88	16959.3	10.12
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	8954.4	31.23	9817.4	21.12	863	(10.12)

Эзэмшигчдийн өмчийн дүн	28672.3	100	46494.6	100	17822.3
-------------------------	---------	-----	---------	-----	---------

Энэ оны эзэмшигчийн өмчийн нийт дүн өмнөх оны мөн үеийнхээс тогтвортой өссөн нь Хорооноос даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг 2.0 тэрбум төгрөгөөс доошгүй байхаар тогтоож өгсөнтэй холбоотой.

#### 2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант үед ердийн даатгалын компаниуд 59,488.1 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Ердийн даатгалын компаниуд даатгалын нийт хураамжийн орлогын 16,332.6 сая төгрөг буюу 27.0 хувийг давхар даатгалд, 404.3 сая төгрөг буюу 1.0 хувийг буцаасан даатгалын хураамжид төлж, 42,751.2 сая төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажилласан байна.

Даатгалын компаниудыг 2012 оны 3 дугаар улиралд олсон даатгалын нийт хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 24.2 хувь буюу 14,375.9 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК бүрдүүлсэн бол “Бодь даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 16.1 хувь буюу 9,604.8 сая төгрөгийг, “Ард даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 11.6 хувь буюу 6,914.7 сая төгрөгийг тус тус бүрдүүлснээр эдгээр компаниудын даатгалын хураамжийн орлого нийт зах зээлийн 51.9 хувийг эзэлсэн байна.

(Хүснэгт-12)  
/сая төгрөгөөр/

№	Даатгагчийн нэр	Даатгалын хураамжийн орлого	Эзлэх хувь
1	“Ард даатгал” ХХК	6,914.7	11.6
2	“Бодь даатгал” ХХК	9,604.8	16.1
3	“Ган зам даатгал” ХХК	633.2	1.1
4	“Мандал женерал даатгал” ХХК	1,461.8	2.5
5	“Жонон даатгал” ХХК	59.4	0.1
6	“МИГ даатгал” ХХК	5,391.6	9.1
7	“Монгол даатгал” ХХК	14,375.9	24.2
8	“Гэр даатгал” ХХК	121.9	0.2
9	“Моннис даатгал” ХХК	1,722.4	2.9
10	“Мөнх даатгал” ХХК	692.3	1.2
11	“Номин даатгал” ХХК	3,697.8	6.2
12	“Практикал даатгал” ХХК	3,694.5	6.2
13	“Тэнгэр даатгал” ХХК	3,881.5	6.5
14	“Соёмбо даатгал” ХХК	4,917.7	8.3
15	“Монре даатгал” ХХК	1,701.9	2.9
16	“УБ хотын даатгал” ХХК	589.9	1.0
17	“Хаан даатгал” ХХК	26.7	0.0
	<b>Дүн</b>	<b>59,488.0</b>	<b>100.0</b>

#### 2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2012 оны 3 дугаар улирлын байдлаар 6,542.3 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 1.5 дахин өссөн байна.

“Монгол даатгал” ХХК нийт нөхөн төлбөрийн 32.7 хувь, “Ард даатгал” ХХК 11.3 хувь, “Миг даатгал” ХХК 11.3 хувийг тус тус бүрдүүлж нийт зах зээлийн 55.3 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-13)

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Даатгалын нөхөн төлбөр	Эзлэх хувь
1	“Ард даатгал” ХХК	1,136.8	11.3
2	“Бодь даатгал” ХХК	991.9	9.8
3	“Ган зам даатгал” ХХК	16.7	0.2
4	“Мандал женерал даатгал” ХХК	60.1	0.6
5	“Жонон даатгал” ХХК	-	0.0
6	“МИГ даатгал” ХХК	1,139.5	11.3
7	“Монгол даатгал” ХХК	3,300.9	32.7
8	“Гэр даатгал” ХХК	8.7	0.1
9	“Моннис даатгал” ХХК	82.4	0.8
10	“Мөнх даатгал” ХХК	108.9	1.1
11	“Номин даатгал” ХХК	686.2	6.8
12	“Практикал даатгал” ХХК	560.4	5.5
13	“Тэнгэр даатгал” ХХК	845.1	8.4
14	“Соёмбо даатгал” ХХК	915.8	9.1
15	“Монре даатгал” ХХК	174.1	1.7
16	“УБ хотын даатгал” ХХК	71.2	0.7
17	“Хаан даатгал” ХХК	-	0.0
	<b>ДҮН</b>	<b>10,098.7</b>	<b>100.0</b>

## 2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын нөхөн олговрын түвшингээр харьцуулахад 2012 оны 3 дугаар улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК 36.6 хувь “Соёмбо даатгал” ХХК 35.5 хувьтай буюу хамгийн өндөр хувьтай байна.

(Хүснэгт-14)

/төгрөгөөр/

	Даатгалын компаниудын нэрс	Орлогод тооцсон хураамж	Нөхөн төлбөр	
1	“Ард даатгал” ХХК	3,321,265,551.50	1 136 784 345.5	34.2
2	“Бодь даатгал” ХХК	3,518,960,240.47	991 920 080.9	28.2
3	“Ган зам даатгал” ХХК	367,781,617.63	16 660 987.0	4.5
4	“Мандал женерал даатгал” ХХК	457,714,440.00	60 112 507.0	0.0
5	“Жонон даатгал” ХХК	140,196,347.00	0.0	0.0
6	“МИГ даатгал” ХХК	3,391,934,537.00	1 139 525 044.0	33.6
7	“Монгол даатгал” ХХК	9,024,057,392.00	3 300 912 612.0	36.6
8	“Гэр даатгал” ХХК	39,835,585.87	8 756 850.9	22.0
9	“Моннис даатгал” ХХК	573,832,692.68	82 397 045.0	14.4
10	“Мөнх даатгал” ХХК	777,725,965.00	108 892 049.0	14.0
11	“Номин даатгал” ХХК	2,254,372,718.82	686 160 330.0	30.4
12	“Практикал даатгал” ХХК	2,671,289,462.00	560 420 971.0	21.0
13	“Тэнгэр даатгал” ХХК	3,285,835,421.93	845 061 308.4	25.7
14	“Соёмбо даатгал” ХХК	2,581,804,635.00	915 785 265.0	35.5
15	“Монре даатгал” ХХК	938,246,208.36	174 081 155.0	18.6

16	“УБ хотын даатгал” ХХК	567,488,522.00	71,162,226.00	12.6
17	“Хаан даатгал” ХХК	9,858,338.50	-	0
	ДҮН	34,352,595,602.00	10 234 485 304.2	29.7

## 2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА

2012 оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 5431.0 сая төгрөг байна. Тайлант үеийн ашиг алдагдлаар нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 1216.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж нийт зах зээлийн 22.4 хувийг эзэлж байгаа бөгөөд “Тэнгэр даатгал” ХХК 612.5 сая төгрөг буюу 11.3 хувь, “Практикал даатгал” ХХК 585.3 сая төгрөг буюу 10.8 хувийг тус тус эзэлж, эдгээр компаниуд нийт зах зээлийн 44.5 хувийг эзэлсэн байна. Тайлант улиралд ердийн даатгалын компаниуд нэгдсэн дүнгээр ашигтай ажилласан байна.

(Хүснэгт-15)

/сая төгрөгөөр/

№	Даатгагчийн нэр	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь
1	“Ард даатгал” ХХК	299.7	5.5
2	“Бодь даатгал” ХХК	370.7	6.8
3	“Ган зам даатгал” ХХК	339.4	6.2
4	“Мандал женерал даатгал” ХХК	(61.5)	-1.1
5	“Жонон даатгал” ХХК	94.9	1.7
6	“МИГ даатгал” ХХК	524.2	9.7
7	“Монгол даатгал” ХХК	1,216.5	22.4
8	“Гэр даатгал” ХХК	12.5	0.2
9	“Моннис даатгал” ХХК	509.4	9.4
10	“Мөнх даатгал” ХХК	60.9	1.1
11	“Номин даатгал” ХХК	464.6	8.6
12	“Практикал даатгал” ХХК	585.3	10.8
13	“Тэнгэр даатгал” ХХК	612.5	11.3
14	“Соёмбо даатгал” ХХК	132.5	2.4
15	“Монре даатгал” ХХК	177.8	3.3
16	“УБ хотын даатгал” ХХК	118.7	2.2
17	“Хаан даатгал” ХХК	(27.1)	-0.5
	<b>Дүн</b>	<b>5,431.0</b>	<b>100.0</b>

## 2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН

2012 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын нөөц сангийн үлдэгдлийн 22.91 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан, 58.92 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан, 0.22 хувийг нэхэмжилсэн хохирлын нөөц, 16.2 хувийг учирсан боловч нэхэмжлээгүй нөөц сан, 1.73 хувийг тусгайлсан нөөц сангууд эзэлж байна.

(Хүснэгт-16)

/сая төгрөгөөр/

Нөөц сан	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Орлогод	18,527.1	30,758.8	21,927.5	27,358.3



<b>тооцоогүй хураамжийн нөөц сан</b>				
<b>Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан</b>	5,820.3	5,514.1	3,810.3	7,524.1
<b>Нэхэмжилсэн хохирлын нөөц сан</b>	74.5	8,995.1	8,96.2	102.5
<b>Учирч болзошгүй нөөц сан</b>	8,646.9	2,336.7	344.6	10,639.1
<b>Тусгайлсан нөөц сан</b>	2,813.2	0.00	2,008.7	804.4
<b>Дүн</b>	<b>35,882.0</b>	<b>47,604.8</b>	<b>37,058.4</b>	<b>46,428.4</b>

Нийт нөхөн төлбөрийн 37.7 хувь нь учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангаас олгогдсон байна.

## 2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

2012 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 16332.2 сая төгрөгийг давхар даатгалд төвлөрүүлсэн байна. “Бодь даатгал” ХХК 26.36 хувь, “Монгол даатгал” ХХК 22.90 хувийг тус тус эзэлж нийт давхар даатгагчид төвлөрүүлсэн хөрөнгийн 49.26 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-17)

/сая төгрөгөөр/

№	Даатгагчийн нэр	2012-III	
		тоо	хувь
1	“Ард даатгал” ХХК	2683	16.43
2	“Бодь даатгал” ХХК	4305.6	26.36
3	“Тэнгэр даатгал” ХХК	571.6	3.50
4	“Практикал даатгал” ХХК	145.4	0.89
5	“Миг даатгал” ХХК	1487.9	9.11
6	“Монгол даатгал” ХХК	3740.8	22.90
7	“Номин даатгал” ХХК	25.6	0.16
8	“Монре даатгал” ХХК	65.7	0.40
9	“Соёмбо даатгал” ХХК	1196.5	7.33
10	“УБ хотын даатгал” ХХК		-
11	“Ган зам даатгал” ХХК	170.5	1.04
12	“Моннис даатгал” ХХК	1077.7	6.60
13	“Мандал женерал даатгал” ХХК	861.9	5.28
		<b>16332.2</b>	<b>100</b>

## 2.9 МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТАЛААР

Малын индексжүүлсэн даатгал /МИД/-ын төсөл нь 2005 оноос эхлэн “ Монгол даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК 2006 оноос “Бодь даатгал” ХХК, 2010 оноос “Практикал даатгал” ХХК, 2011 оноос “Монре даатгал” ХХК-иудтай хамтран малчдын

амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргийг зуд, байгалийн гамшигт үзэгдлээс хамгаалах тогтолцоог Монгол Улсад анх удаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Хорооны 2011 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 177 дугаар тогтоолоор “Малын индексжүүлсэн даатгалыг бүртгэх, тайлагнах түр заавар”-ыг батлан гаргасан бөгөөд уг зааврын дагуу малын индексжүүлсэн даатгалын төслийг хэрэгжүүлж буй ердийн даатгалын компаниудыг орлого урьдчилсан байдлаар дараах байдалтай байна.

(Хүснэгт-18)

/сая төгрөгөөр/

№	Даатгагчийн нэр	Малчны төлсөн хураамж	Орлогод тооцсон хураамж	Үйл ажиллагааны зардал	2011 оны нөхөн төлбөр
1	“Монгол даатгал” ХХК	626.4	417.6	208.8	48.3
2	“Практикал даатгал” ХХК	181.8	121.2	60.6	28.7
3	“Тэнгэр даатгал” ХХК	340.1	226.7	113.2	13.3
4	“Бодь даатгал” ХХК	325.4	216.9	108.5	21.7
5	“Монре даатгал” ХХК	23.8	15.8	7.9	
	<b>Нийт дүн</b>	<b>1,497.5</b>	<b>998.2</b>	<b>499.0</b>	<b>112</b>

“Практикал даатгал” ХХК нь МИД-ын тайланг 2012 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд тусгасан бөгөөд бусад компаниудын хувьд тусгаагүй байгаа бөгөөд МИД-ын төсөл хэрэгжүүлэх нэгжтэй тооцоо нийлсэний дараа 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгахаар болсон байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

### 3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Даатгалын зах зээл дээр “Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагааг 2008 оноос хойш явуулж байна. Байгуулагдсан цагаас хойшхи нийт хөрөнгийн хэмжээ 2130.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Сүүлийн 4 жилийн мөн үеийн байдлаар дараах байдалтай байна. (График-9)

/сая төгрөгөөр/



Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс 61.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, ДАВХАР ДААТГАЛ, ДАВХАР ДААТГАЛ

Урт хугацааны даатгалын компани 2012 оны 3 дугаар улирлын байдлаар 430.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 11.2 сая төгрөгийг давхар даатгагчид төвлөрүүлж, 135.9 сая төгрөгийг нөхөн төлбөрт төлжээ. Сүүлийн 4 жилийн байдлаар орлого, давхар даатгал, нөхөн төлбөрийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулбал:

(Хүснэгт-19)

*/сая төгрөгөөр/*

	2009.9.30	2010. 9.30	2011.9.30	2012.9.30
<b>Хураамжийн орлого</b>	-	160.5	227.9	430.4
<b>Давхар даатгал</b>	5.9	50.6	56.5	11.2
<b>Нөхөн төлбөр</b>	-	30.3	41.6	135.9

Тус компанийн даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөр 2010 оноос тогтмол нэмэгдэж ирсэн байна.

### 3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА, НӨӨЦ САН

Урт хугацааны даатгагч нь 2008 оноос хойш алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээ 788.8 сая төгрөгт хүрчээ. Энэ нь нийт эзэмшигчийн өмчийн 27.1 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-20)

*/сая төгрөгөөр/*

	2009.9.30	2010.9.30	2011.9.30	2012.9.30
<b>Хуримтлагдсан ашиг (алдагдал)</b>	-462.0	-421.0	-658.1	-788.8
<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	-121.5	-88.9	-183.5	-142.2
<b>Нөөц сан</b>	-	69.2	164.7	449.9

2010 оноос нөөц сангийн тайланг тайлагнасан байна.

(Хүснэгт-21)

*/сая төгрөгөөр/*

<b>Даатгалын нөөц</b>	2009.9.30	2010.9.30	2011.9.30	2012.9.30
<b>Хувь оролцоотой гэрээний нөөц сан</b>	-			
<b>Хувь оролцоогүй гэрээний нөөц сан</b>	-	69.2	164.7	449.9
<b>Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан</b>	-			
<b>ДҮН</b>	-	69.2	164.7	449.9

Даатгалын нөөц сан 2012 оны 3 дугаар улирлын байдлаар 449.9 сая төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 354.4 сая төгрөгөөр өссөн байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

### 4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант оны 3 дугаар улиралд нийт 12 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 433.5 сая төгрөг болсон байна.

(Хүснэгт-21)

/сая төгрөгөөр/

№	Зуучлагч компанийн нэр	2011.09.30	2012.09.30	Өсөлт бууралт
1	“Асимон брокерс” ХХК	19.6	117.9	98.3
2	“АМЕ” ХХК	10.1	85	74.9
3	“Ачит ундарга” ХХК	45.5	49.9	4.4
4	“Лоялти солюшн” ХХК	6.3	52.3	46.0
5	“Эм Жи Ай Би” ХХК	14.1	13.4	-0.7
6	“Ренессанс групп” ХХК	30.4	46.3	15.9
7	“Жомолхари” ХХК	17.7	0	-17.7
8	“Монголиан интернэшнл брокерс” ХХК	44.8	0	-44.8
9	"Юу ай би" ХХК		10.7	10.7
10	"Си эн эн икс" ХХК		49.4	49.4
11	Изи инвестмент ХХК		8.6	8.6
12	Гэрэлт буян ундрах ХХК		0	0
	<b>Нийт дүн</b>	<b>188.5</b>	<b>433.5</b>	<b>245</b>

Хураамжийн орлогыг тайлант оныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Асимон брокерс” ХХК 98.3 сая төгрөгөөр, “Аме” ХХК 74.9 сая төгрөгөөр, “Лоялти солюшн” ХХК 46.0 сая төгрөгөөр тус тус буурч, “Ачит ундарга” ХХК 4.4 сая төгрөгөөр, “Ренессанс групп” ХХК 15.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, “Эм жи ай би” ХХК 0.7 сая төгрөгөөр “Жомолхари” ХХК 17.7 сая төгрөгөөр, “Монголиан интернэшнл брокерс” ХХК нь 44.8 сая төгрөгөөр тус тус буурсан байна. 2012 онд шинээр тусгай зөвшөөрөл авсан “Юу ай би” ХХК, “Си эн эн икс” ХХК, “Изи инвестмент” ХХК-иуд нийтдээ 68.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

“Асимон брокерс” ХХК, “Лоялти солюшн” ХХК-иуд нийт даатгалын зуучлалын үндсэн үйл ажиллагааны орлогын 39.2 хувийг эзэлсэн байна.

### 4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 84.16 сая төгрөг байна.

(Хүснэгт-22)

/сая төгрөгөөр/

№	Үнэлэгч компанийн нэр	2011.09.30	2012.09.30	Өсөлт бууралт
1	“Бест эстимэйт” ХХК	4.7	10.5	5.8
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	34.2	31.9	-2.3
3	“Файн эстимэйт” ХХК	0	0	0
4	“Итгэлт эстимэйт” ХХК	71.5	20.1	-51.4
5	“Мега марз” ХХК	5.9	0	-5.9
6	“Вендо” ХХК	0.4	15.5	15.1
7	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	24.9	0.06	-24.84
8	"Жи ай си си" ХХК	0	2.3	2.3
9	"Арвижих эстимэйт" ХХК	0	3.8	3.8
	<b>Нийт дүн</b>	<b>141.6</b>	<b>84.16</b>	<b>-57.44</b>

Тайлант үеийн хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Бест эстимэйт” ХХК 5.8 сая төгрөгөөр, “Вендо” ХХК 15.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, “Гэрэгэ эстимэйт” ХХК 2.3 сая төгрөгөөр, “Итгэлт эстимэйт” ХХК 51.4 сая төгрөгөөр, “Мега марз” ХХК 5.9 сая төгрөгөөр, Хөрөнгийн үнэлгээний төв 24.84 төгрөгөөр тус тус буурсан байна.

2012 онд шинээр тусгай зөвшөөрөл авсан “Жи ай си си” ХХК, “Арвижих эстимэйт” ХХК-иуд нийт 6.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

## ДҮГНЭЛТ

Даатгалын салбарын хөгжлийн динамик үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг сүүлийн жилүүдийн байдлаар нэгтгэн дүгнэж үзэхэд даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тоо сүүлийн хоёр жилд эрс нэмэгдэх хандлагатай болсон байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулахад 1.3 дахин өсч 100.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант үеийн цэвэр ашиг 5.3 тэрбум төгрөгт хүрч санхүүгийн чадавхи нэмэгдэж, цаашид даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтүүд сайжрах төлөвтэй байгааг илтгэн харуулж байна.

Даатгалын салбарын хэмжээнд тайлант хугацаанд даатгалын компаниудын олсон нийт хураамжийн орлого 59.5 тэрбум төгрөгт хүрсэн нь 2011 оны жилийн эцсийн борлуулалтын орлогоос 1.3 дахин их байна. Энэ нь 2012 оноос “Жолоочийн даатгалын тухай” хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байна.

Даатгалын зах зээлийн дийлэнх үзүүлэлтүүд эерэг хандлагатай, өсөлттэй гарсан хэдий ч дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай байна.

1. Салбарын даатгалын гэрээний нийт үнэлгээ 16 832.7 тэрбум төгрөг, даатгалын хураамжийн орлого 59.9 тэрбум төгрөг, үүнээс давхар даатгагчид шилжүүлсэн орлого 16.3 тэрбум төгрөг байна. Эндээс дүгнэвэл даатгалын байгууллагад нийт үнэлгээ буюу эрсдэлийн 73 орчим хувь үлдэж байгаа тул даатгалын салбарын эрсдэлийн удирдлагыг сайжруулах шаардлагатай.

2. Салбарын хэмжээнд зарим дүн шинжилгээг хийж үзэхэд хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж нь 42.3 хувь буюу өндөр (*Хөрөнгийн өгөөж = цэвэр орлого / нийт хөрөнгө*), хөрөнгө оруулалтын өгөөж 5.0 хувь буюу харьцангуй бага (*ХО-ын өгөөж = ХО-ын орлого / нийт хөрөнгө*) үзүүлэлттэй байна. Нөхөн олговрын түвшин 29.7 хувь буюу (*Нөхөн олговрын түвшин = Нөхөн төлбөр / ОТХ*) өмнөх оны мөн үеэс буурсан дүнтэй байна. Ердийн даатгалын ажиллагааны зардлын орлогод тооцсон хураамжид эзлэх хувь хэмжээ (*Ажиллагааны зардал =  $Y A 3 / O T X$* ) 62.7 хувь буюу өндөр байна.

## ДААТГАЛЫН ГАЗАР